

Нисэх загварын спортын шүүгч нарт тавигдах

шаардлага, цол зэрэг олгох журам

2015-05-03

Улаанбаатар хот

1. Ерөнхий зүйл

- 1.1. Нисэх загварын спорт нь тамирчнаас шудрага өрсөлдөөн, ур чадвар, авхаалж самбаа, ур ухаан шаардсан спорт юм. Нисэх загварын тэмцээнийг өндөр түвшинд явагдахад ур чадвартай, тэмцээний явцад үүсэх аливаа асуудал, маргаан зөрчлийг ухаалгаар шийдэж чадах шүүгч нарын үүрэг чухал нөлөө үзүүлнэ.
- 1.2. Нисэх загварын спортын хөгжлийг олон улсын түвшинд хүргэж, зөв үнэлэмж, зөв гольдирлоор явуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Шүүгчдийн баримтлах ёс зүй

- 2.1. Шүүгч нь нисэх загварын спортын дүрмийг зөрчихгүй байх, тэмцээний үр дүнд сөргөөр нөлөөлөхүйц үйлдэл гаргахгүй байх
- 2.2. Шүүгч нь тэмцээнд оролцож буй тамчирдад ижил тэгш зарчмаар хандах, өөрийн танил, найз нөхдөд ёс бусаар үйлчлэхгүй байх, хувийн үзэл бодол харилцааг илэрхийлэхгүй байх
- 2.3. Тэмцээний явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглох
- 2.4. Цаг нарийн баримтлах
- 2.5. Үүссэн нөхцөл байдалд өөрийгөө эзэмдэн хянах чадвартай байх
- 2.6. Өөрийн ажил үүргээ хариуцлагатай биелүүлэх, бусдад үүргээ шилжүүлэх, хариуцлагаас зайлсхийхгүй байх
- 2.7. Найрсаг нөхөрсөг харьцааг эрхэмлэх
- 2.8. Мэдлэгийн түвшин, дүрмийн мэдлэгээ байнга дээшлүүлж байх
- 2.9. Нийгэмлэгээс баталсан тэмцээн уралдаанд тогтмол оролцох

3. Шүүгчийн цол

- 3.1. Нисэх загварын спортын төрлүүдийг шүүх шүүлт нь өөр өөр ур чадвар, мэдлэг, мэдрэмж, ажиллагаа шаардах тул үндсэн гурван төрөл тус бүрт I-III

зэрэг олгоно. Ж: F1 буюу чөлөөт нислэгийн II зэргийн шүүгч, F2 буюу жолоодлогот загварын I зэргийн шүүгч, F3 буюу радио удирдлагат загварын III зэргийн шүүгч г.м.

3.2. Үндсэн 3 төрлөөр I зэргийн шүүгчийн болзол хангасан хүнд “Монгол Улсын шүүгч” цол олгоно.

4. Шүүгчийн цол зэрэг олгох журам

4.1. “Монгол Улсын шүүгч” цолыг Монгол улсын цол, зэргийн комиссод Монголын нисэх загварын спортын нийгэмлэгийн тодорхойлолтоор олгоно.

4.2. I-III зэргийг Монголын нисэх загварын спортын нийгэмлэгийн Ерөнхийлөгчийн тушаалаар олгож, үнэмлэхээр баталгаажуулна.

4.3. III зэргийг шүүгчид тавигдах шаардлага:

- Шүүгчдийн семинарт оролцож дүрмийн зохих мэдлэгтэй болсон байх,

4.4. II зэргийн шүүгчид тавигдах шаардлага:

- Олон улс, улс, хотын чанартай тэмцээнд 3-р зэрэгтэйгээр 3-аас дээш удаа ажиллаж, тэмцээний Ерөнхий шүүгчээс “хангалттай” үнэлгээ авсан байх,
- Дүрмийн болон тэмцээн зохион байгуулж явуулах талаар Монголын нисэх загварын спортын нийгэмлэгийн Удирдах зөвлөлд шалгалт өгч “тэнцсэн” үнэлгээ авсан байх,

4.5. I зэргийн шүүгчид тавигдах шаардлага:

- Улс, хотын тэмцээнд нарийн бичгийн шүүгч, ахлах шүүгчээр 3 удаа ажилласан байх,
- Дүрмийн болон тэмцээн зохион байгуулж явуулах талаар Монголын нисэх загварын спортын нийгэмлэгийн Удирдах зөвлөлд шалгалт өгч “тэнцсэн” үнэлгээ авсан байх,
- Бие дааж тэмцээн зохион байгуулах чадвартай байх.

5. Шүүгчийн үүрэг

5.1. Шүүгчээр ажиллаж байгаа хүн тэмцээний явцад үнэмлэхээ харагдахуйц газар заавал зүүнэ.

5.2. Шүүгч нь Монголын нисэх загварын спортын нийгэмлэгээс олгсон ажлын дэвтэртэй байх бөгөөд тэмцээний зэрэглэлээс хамааран жилд зайлшгүй шүүх тэмцээн, хамрагдах сургалт, бусад үйл ажиллагааны оролцоо зэргийг байнга тэмдэглүүлж байна.

- 5.3. Нисэх загварын спортын нэг хүндийг байнга эрхэмлэн дээдлэж, нэр хүндэд харш аливаа асуудал, үзэгдлийн эсрэг урс тууштай байж, түүнийг залруулах, зогсоох, зөв болгох
- 5.4. Тэмцээнийг зөв шударга явуулахад идэвхитэй оролцож, өөрийн үүргээ хариуцлагатай биелүүлэх

6. Шүүгчийн цол зэргийн урамшуулал

- 6.1. Тэмцээнд ажилласан шүүгч нь өөрийн цол зэрэг, гүйцэтгэсэн албан тушаалдаа тохирсон урамшуулал авна.
- 6.2. Шүүгчийн цол зэргийн урамшууллыг Монголын нисэх загварын нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн хурлаар тогтооно.
- 6.3. 2015-05-03-ны өдрийн шийдвэр /өөрчлөлт орсон/ мөрдөгдөж байна.

Шүүгчийн цол зэрэг	А зэрэглэлийн тэмцээн	В зэрэглэлийн тэмцээн
Улсын шүүгч	25000	20000
1-р зэргийн шүүгч	20000	15000
2-р зэргийн шүүгч	15000	10000
3-р зэргийн шүүгч	10000	5000
Зэрэггүй шүүгч	5000	3000

- 6.4. Тэмцээнд гүйцэтгэсэн албан тушаалын урамшуулал нь цол зэргийн урамшууллын хэмжээнээс доорхи %-иар тооцогдоно.

Албан тушаал	Урамшууллын %
Аж ахуйн шүүгч	30%
Нарийн бичгийн шүүгч	50%
Ахлах шүүгч	75%
Ерөнхий шүүгч	100%

- 6.5. Тухайн тэмцээнд албан тушаал хавсарч гүйцэтгэсэн бол дээд албан тушаалын нэмэгдлээр тооцно.
- 6.6. Албан тушаалын үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн шүүгчийн урамшууллыг тэмцээний Ерөнхий шүүгчийн үнэлгээгээр 50% бууруулж болно.
- 6.7. Шүүгч тухайн тэмцээний F1, F2, F3 ангилалд шүүгчээр зэрэг ажилласан бол шүүсэн ангилал тус бүрт дээр заасан урамшууллыг бодож олгоно.

6.8. Харин энэхүү ангилал дотор F2B, F2D төрөлд шүүгчээр зэрэг ажилласан бол шүүсэн нэмэлт төрөл тус бүрт дээр заасан цалингийн 50%-ийг бодож олгоно. Гэхдээ чөлөөт нислэгийн төрлүүдэд энэхүү заалт хамаарахгүй.

Тайлбар жишээ: А зэрэглэлийн тэмцээнд 1-р зэргийн шүүгч ахлах шүүгчээр ажилласан бол $20000+(0.75*20000)=35000$ төгрөгний урамшуулалтай. Мөн энэ тэмцээнд Улсын шүүгч цолтой хүн гарааны шүүгчээр ажилласан бол 25000 төгрөгний урамшуулалтай.